



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 531

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2019-2020 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн Улсын байцаагчийн баримтын шалгалтаар нийт 1,264.4 (нэг тэрбум хоёр зуун жаран дөрвөн сая дөрвөн зуун мянган) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөсүгэй.

1.1. Компанийн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллах;

1.2. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд хяналт тавьж ажиллаж үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдах болон эрх бүхий албан тушаалтан нарт хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

2. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит компанийн 2019-2020 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б. Насантогтох, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит компанийн гүйцэтгэх захирал Р. Дагдан нарт санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

3.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

3.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг олж авахдаа Төрийн өмчийг бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч ажиллах;

3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактаар олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй байх;

3.4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтын дагуу хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;

132001571

3.5. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 8 дугаар тогтоолын 2.2-д төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхгүй байх;

3.6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3-т заасан тендер шалгаруулалт амжилтгүй болж, 34.1-т заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал өрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлж байх;

3.7. Гадаад болон дотоод албан томилолтын хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах;

4. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА





 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2021 оны 11 дүгээр сарын 11.-ны өдрийн
 53/дугаар тогтоолын хавсралт

**Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах
арга хэмжээний жагсаалт**

№	Зөрчил, дутагдлын утга		Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Худалдан авах ажиллагаа	Эрх бүхий байгууллагад компанийн сонгон шалгаруулалтын гэрээ, шалгаруулсан үндэслэлийн талаарх тайлбарыг хүргүүлж ажиллаагүй	Захирал Р.Дагдан Ерөнхий ня-бо О.Ариунболд	789,632.09	"Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34.3. заалтыг мөрдөж ажиллах
		Тендер шалгаруулалтын арга журмыг буруу хэрэглэсэн худалдан авалт		311,760.00	"Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34.3. заалтыг мөрдөж ажиллах
		Зориулалтыг нь өөрчилсөн худалдан авах ажиллагаа:		44,490.50	Төсвийн хууль, ТҮЗ-ын тогтоолыг мөрдөж ажиллах
2	Хуулийн дагуу суутгаж төсөвт төвлөрүүлээгүй ХХОАТ		Захирал Р.Дагдан Ерөнхий ня-бо О.Ариунболд	24,043.80	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг мөрдөж ажиллах
3	Үргүй зардал	ЭХХТ-ийн сургалтын төвийн үйл ажиллагаанд төвлөрүүлсэн хөрөнгө	Захирал Р.Дагдан Ерөнхий ня-бо О.Ариунболд	44,200.00	Төсвийн хууль, Компанийн тухай хууль, Захирлын контрактын гэрээний заалтыг мөрдөж ажиллах
		Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, зарим гишүүдэд олгосон урамшуулал, шатахууны зардал		21,196.00	
4	Салбарын дээд шатны байгууллагын гадаад томилолтын зардлыг хариуцсан		Захирал Р.Дагдан Ерөнхий ня-бо О.Ариунболд	29,087.80	Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах
Нийт дүн /мян.төгр/				1,264,410.19	